



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/119/СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Дорноговь аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: enkhsetseg.e@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан.....	6
2.1. Оршил .....	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	6
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	7
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал .....	13
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22

## Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	<b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Г.ЭРДЭНЭБААТАР ТАНАА</b>
2020.02.21 № 1-6/110 танай _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Хязгаарлалттай санал дүгнэлт</b>	
<p>Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

### Аудитын гол асуудал

1. Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар нь 80 жилийн ойн хүрээнд кассаар 5,700.0 мянган төгрөг, арилжааны банкны дансаар дамжуулан цагдаагийн албан хаагчид, ахмад ажилтнуудаас 60,158.0 мянган төгрөг, Хувийн компаниудаас 30,000.0 мянган төгрөгийн хандивын орлого авч, 22,750.0 мянган төгрөгийн /чонын чихмэл, 15-ны Цагдаагийн хөшөө, биеийн тамирын талбай, тавилга эд хогшил/ хөрөнгө бэлтгэж, 73,108.0 мянган төгрөгийг ойн үйл ажиллагаанд зарцуулж, 9,367.2 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Мөн Дорноговь хөгжлийн сангаас кассаар 20,000.0 мянган төгрөгийн хандивын орлого авч, 15,102.2 төгрөгийн /Хамгаалах байрны дотоод тохижилт/ хөрөнгө бэлтгэсэн байна.

Эрэн хотын Цагдаагийн газраас кассаар 3,881.0 мянган төгрөг /10,000 юань/-ийн хандивын орлого авч, 1,895.1 мянган төгрөгийн /Шинэ давхрын өрөөний тохижилт/ хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь (эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна. Мөн Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д "хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно", 25.4-д "төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх, байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно" гэж заасныг зөрчсөн байна.

2. Байгууллагын үндсэн цалингийн зардлаас малчинд 3,968.0 мянган төгрөгийн цалин олгосон.

Энэ нь (үнэн зөв байдал, эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д "үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.


Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын тайланд материаллаг байдлын түвшинг 21,782.9 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн үе шатанд илэрсэн зөрчил нь 123,707.0 мянган төгрөг буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 5 дахин давсан байна.

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Г.Эрдэнэбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 11-ээс 2020 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 35-1/236 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь хуулийг дээдлэн, хүний эрхийг хамгаалах, амар тайван амьдралын баталгааг хангахад оршино.

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “acalous” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 30 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,583,715.8 мянган төгрөгөөс тооцон 15,837.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 21,782.9 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 376,368.5 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	47.4	79.4	32.0
Урьдчилгаа	29,884.3	2,206.7	-27,677.6
Бараа материал	382,357.2	439,309.7	56,952.5
Үндсэн хөрөнгө	3,203,395.9	3,550,457.5	347,061.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,615,684.9</b>	<b>3,992,053.4</b>	<b>376,368.5</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,615,684.9	3,992,053.4	376,368.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,615,684.9</b>	<b>3,992,053.4</b>	<b>376,368.5</b>

Авлага дансны үлдэгдэлд байгууллагаас авах 79.4 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь байгууллагын тамга хийлгэхээр захиалаад хийлгэхээ больсон тул авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 56,952.5 мянган төгрөгөөр өссөн нь тусгай хэрэгсэл 1,794.1 мянган төгрөг, эм боох материал 107.4 мянган төгрөг, хувцас бэлэн бүтээгдэхүүн 2,835.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 238.4 мянган төгрөг, түлш шатах тослох материал 5,105.8 мянган төгрөг, бусад хангамжийн материал 45,870.5 мянган төгрөг, мал амьтад 5,221.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 347,061.6 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын конторын барилгыг өргөтгөж 1 давхар нэмж барьсан, түр хамгаалах байрыг балансаас балансад шилжүүлэн авснаас шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 142,561.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 39,747.3 мянган төгрөг, балансаас балансад 59,452.7 мянган төгрөг, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн дахин үнэлгээгээр 113,810.0 мянган төгрөг, барилгын өргөтгөл 250,000.0 мянган төгрөгөөр сайжруулалт хийж 598,390.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгө 310,546.0 мянган төгрөгийн хөрөнгөөр, 1 автомашин акталсан 20,200.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 2,857.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 376,368.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 6,924.5 мянган төгрөгийн бичилт нь дахин үнэлгээний зөрүүгээс шалтгаалсан байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар тайлант онд 55,226.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 60,335.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Монгол банкны гэрээтийн цалин	42,709.5	46,820.8	4,111.3	109
Эрүүлжүүлэхийн хураамж	2,626.1	2,626.1	0.0	100
Журмын хашааны хураамж	4,483.2	4,483.2	0.0	100
Баривчлагдсан хүний шууд зардал	5,407.2	5,407.2	0.0	100
Бусад орлого	0	998.0	998.0	0
<b>Нийт дүн</b>	<b>55,226.0</b>	<b>60,335.3</b>	<b>-5,109.3</b>	<b>109</b>

Монгол банкны гэрээтийн цалин нь 2019 оны 1 дүгээр сарын 1-ээс Засгийн газрын 24 дүгээр тогтоолын дагуу цалин 8 хувь өссөнөөс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр 4 зориулалтад 1,885,389.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,882,378.9 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 3,010.5 мянган төгрөгийг бусад урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,830,163.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 55,226.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,883,992.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,579,189.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 33,244.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 97,499.8 мянган төгрөг, хангамж бараа материал 95,556.2 мянган төгрөг, норматив зардал 21,699.7 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 35,042.4 мянган төгрөг, томилолт зочны зардал 14,360.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 2,392.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,997.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 3,010.0 мянган төгрөг/ нийт дүнгээр 1,396.6 мянган төгрөг хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 4,150.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 2,340.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын санхүүгийн дэмжлэгээр 10,000.0 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс 2,734.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 120.0 мянга, нийт 19,344.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс худалдан авахад 5,534.1 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 315.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 2,835.0 мянган төгрөг, багаж техник худалдан авахад 420.0 мянган төгрөг, тавилга хэрэгсэл худалдан авах 7,780.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 120.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2,340.0 мянган төгрөг нийт 19,344.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл төвлөрүүлээгүй байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 43,715.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 43,715.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 138 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 29,884.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1 Зардлын данстай холбоотой асуудал

#### 1.1 Илрүүлэлт:

*Үндсэн цалингийн зардлаас малчинд 3,968.0 мянган төгрөгийн цалин олгосон.*

Энэ нь (үнэн зөв байдал, эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 “үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

#### 1.2 Эрсдэл:

*Хууль, дүрэм журам зөрчигдөх.*

#### 1.3 Өгсөн зөвлөмж:

*Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйл “Туслах үйл ажиллагаа”-ийг мөрдөж ажиллах.*

### 2 Балансын данстай холбоотой асуудал

#### 2.1 Илрүүлэлт:

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 80 жилийн ойн хүрээнд кассаар 5,700.0 мянган төгрөг, арилжааны банкны дансаар дамжуулан цагдаагийн албан хаагчид, ахмад ажилтнуудаас 60,158.0 мянган төгрөг, Хувийн компаниудаас 30,000.0 мянган төгрөгийн хандивын орлого авч, 22,750.0 мянган төгрөгийн /чонын чихмэл, 15-ны Цагдаагийн хөшөө, биеийн тамирын талбай, тавилга эд хогшил/хөрөнгө бэлтгэж, 73,108.0 мянган төгрөгийг ойн үйл ажиллагаанд зарцуулж, 9,367.2 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Дорноговь хөгжлийн сангаас Цагдаагийн газрын төв байрны өргөтгөлийн ажилд 250,000.0 мянган төгрөг, кассаар 20,000.0 мянган төгрөгийн хандивын орлого авч, 15,102.2 төгрөгийн /Хамгаалах байрны дотоод тохижилт/ хөрөнгө бэлтгэсэн байна.

Эрээн хотын Цагдаагийн газраас кассаар 3,881.0 мянган төгрөг /10,000 юань/-ийн хандивын орлого авч, 1,895.1 мянган төгрөгийн /Шинэ давхрын өрөөний тохижилт/ хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь (эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.4 дэх заалтыг зөрчсөн байна.

## 2.2 Эрсдэл:

*Хууль, дүрэм журам зөрчигдөх, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй.*

## 2.3 Өгсөн зөвлөмж:

*Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 25.2-д “хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно”, 25.4-д “төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх, байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно” заалтыг хэрэгжүүлж ажиллах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>412,289,008.62</b>	<b>441,595,817.91</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	47,418.77	79,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	47,418.77	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	79,400.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	79,400.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	29,884,346.09	2,206,708.09
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	29,884,346.09	2,206,708.09
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	29,884,346.09	2,206,708.09
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	382,357,243.76	439,309,709.82
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	65,206,337.65	67,108,032.85
35110	Тусгай зориулалттай материал	64,491,706.65	66,285,805.25
35130	Эм боох материал	714,631.00	822,227.60
35300	Бэлэн бүтээгдэхүүн	19,905,180.00	22,740,180.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	286,557,726.11	333,551,608.97
35410	Бичиг хэргийн материал	18,288,736.35	18,473,287.31
35420	Аж ахуйн материал	31,644,453.40	28,785,856.80
35430	Сэлбэг хэрэгсэл	2,640,010.00	2,397,300.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	5,105,780.00
35450	Барилгын засварын материал	100,900.00	00.00
35460	Хүнсний материал	964,741.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	232,918,885.36	278,789,384.86
35600	Мал амьтад	10,688,000.00	15,909,888.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,203,395,923.91</b>	<b>3,550,457,598.07</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,203,395,923.91	3,550,457,598.07
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,670,445,923.91	3,009,777,598.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,113,979,233.31	2,422,651,136.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,810,318.21	-102,301,786.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	377,179,395.04	258,149,035.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	-243,659,290.14	-115,461,546.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	558,791,607.51	620,927,420.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-227,568,479.96	-202,368,151.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78,343,470.58	82,444,642.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,843,325.22	-27,226,638.33
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	39,726,656.00	39,726,656.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,023,275.00	38,566,975.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,716,300.00	-5,330,145.03
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	532,950,000.00	540,680,000.00
39301	Програм хангамж	4,507,341.80	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,507,341.80	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	532,950,000.00	539,030,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,615,684,932.53</b>	<b>3,992,053,415.98</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,615,684,932.53</b>	<b>3,992,053,415.98</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,615,684,932.53	3,992,053,415.98

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,306,600,680.75	1,306,600,680.75
51101	Өмч: - төрийн	1,306,600,680.75	1,306,600,680.75
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,238,549,547.49</b>	<b>1,621,842,536.27</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,238,549,547.49	1,245,474,052.82
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	376,368,483.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,070,534,704.29	1,063,610,198.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,615,684,932.53</u></b>	<b><u>3,992,053,415.98</u></b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,362,300,584.75</b>	<b>2,554,668,420.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>336,906,054.75</b>	<b>705,161,020.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	336,906,054.75	705,161,020.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	336,906,054.75	705,161,020.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,190,388.00	61,057,023.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	277,715,666.75	644,103,997.26
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,025,394,530.00</b>	<b>1,849,507,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,602,424,600.00	1,830,163,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,602,424,600.00	1,830,163,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	85,432,785.00	19,344,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,600,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,851,985.00	2,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,980,800.00	12,854,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	337,537,145.00	00.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	337,537,145.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,853,165,707.47</b>	<b>2,178,299,936.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,853,165,707.47</b>	<b>2,178,299,936.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,849,669,000.62	2,168,784,016.30
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,353,632,110.00	1,579,316,565.00
210101	Үндсэн цалин	700,500,245.00	813,203,678.00
210102	Нэмэгдэл	653,131,865.00	766,112,887.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,404,590.78	33,886,364.58
210201	Тэтгэврийн даатгал	2,226,703.90	2,210,776.01
210202	Тэтгэмжийн даатгал	287,937.52	261,162.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	222,670.63	208,929.90
210204	Ажилгүйдлийн даатгал	55,667.96	45,184.66
210205	Эрүүл мэндийн даатгал	26,611,610.77	31,160,311.49
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	75,523,809.00	97,499,855.58
210301	Гэрэл, цахилгаан	14,908,160.00	17,326,919.58
210302	Түлш, халаалт	54,830,528.00	74,066,602.00
210303	Цэвэр, бохир ус	5,785,121.00	6,106,334.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	146,913,549.65	124,925,713.44
210401	Бичиг хэрэг	9,957,969.90	9,819,568.04
210402	Тээвэр, шатахуун	85,613,317.10	97,612,130.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,948,872.50	7,721,118.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	620,000.00	647,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,387,521.65	5,281,678.50
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	32,282,682.50	00.00
210408	Бараа материал ақталсны зардал	9,103,186.00	3,843,717.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	24,743,184.50	24,515,626.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	437,878.50	392,390.40
210502	Хоол, хүнс	23,977,806.00	23,963,536.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	327,500.00	159,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>41,033,373.50</b>	<b>31,646,477.80</b>
210604	Урсгал засвар	41,033,373.50	31,646,477.80
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,317,600.00</b>	<b>14,360,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,317,600.00	14,360,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,559,747.00</b>	<b>2,446,607.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,533,300.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.00	800,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	172,500.00	195,000.00
210807	Газрын төлбөр	437,847.00	965,737.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	40,100.00	53,870.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>155,541,036.19</b>	<b>260,186,806.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,890,000.00	8,010,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,954,954.20	847,572.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	151,696,081.99	251,329,234.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,496,706.85</b>	<b>9,515,920.51</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>3,010,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,010,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,496,706.85</b>	<b>6,505,920.51</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,447,706.85	6,505,920.51
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>509,134,877.28</b>	<b>376,368,483.45</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,833,333.30</b>	<b>00.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,833,333.30	00.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>113,837,620.27</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,390,633.18	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	106,446,987.09	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-112,004,286.97</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>397,130,590.31</b>	<b>376,368,483.45</b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,747,047,773.00</b>	<b>1,909,842,744.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>59,190,388.00</b>	<b>60,335,344.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	59,190,388.00	60,335,344.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	59,190,388.00	60,335,344.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,190,388.00	60,335,344.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,687,857,385.00</b>	<b>1,849,507,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,602,424,600.00	1,830,163,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,602,424,600.00	1,830,163,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	85,432,785.00	19,344,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,600,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,851,985.00	2,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,980,800.00	12,854,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,674,950,564.00</b>	<b>1,901,642,794.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,674,950,564.00</b>	<b>1,901,642,794.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,671,453,857.15</b>	<b>1,892,126,873.49</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,353,707,380.55	1,579,189,209.00
210101	Үндсэн цалин	889,825,680.55	915,454,163.00
210102	Нэмэгдэл	463,881,700.00	663,735,046.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,392,467.00	33,244,622.81
210201	Тэтгэврийн даатгал	2,623,000.00	94,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	11,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	8,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	2,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,769,467.00	33,128,122.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	75,523,809.00	97,499,855.58
210301	Гэрэл, цахилгаан	14,908,160.00	17,326,919.58
210302	Түлш, халаалт	54,830,528.00	74,066,602.00
210303	Цэвэр, бохир ус	5,785,121.00	6,106,334.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	114,127,161.60	101,090,314.30
210401	Бичиг хэрэг	10,695,908.00	8,675,696.00
210402	Тээвэр, шатахуун	86,325,063.10	72,185,252.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,741,274.50	7,771,518.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	620,000.00	647,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,744,916.00	11,810,347.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,676,273.00	24,849,779.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	499,230.00	499,987.00
210502	Хоол, хүнс	21,677,043.00	20,931,092.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	3,418,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	50,199,699.00	35,162,444.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,103,990.00	00.00
210602	Тавилга	830,500.00	00.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	999,300.00	00.00
210604	Урсгал засвар	46,265,909.00	35,162,444.80
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,317,600.00</b>	<b>14,360,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,317,600.00	14,360,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,517,147.00</b>	<b>4,732,737.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,533,300.00	2,340,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.00	800,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	170,000.00	195,000.00
210807	Газрын төлбөр	437,847.00	965,737.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,992,320.00</b>	<b>1,997,911.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,992,320.00	1,997,911.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,496,706.85</b>	<b>9,515,920.51</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>3,010,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,010,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,496,706.85</b>	<b>6,505,920.51</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,447,706.85	6,505,920.51
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>72,097,209.00</u></b>	<b><u>8,199,950.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>72,097,209.00</u></b>	<b><u>8,199,950.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>72,097,209.00</u></b>	<b><u>8,199,950.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>72,097,209.00</b>	<b>8,199,950.00</b>
220001	Барилга байгууламж	28,425,992.50	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	43,671,216.50	8,199,950.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-72,097,209.00</u></b>	<b><u>-8,199,950.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>773,650,680.75</b>	<b>580,108,566.00</b>	<b>840,811,382.54</b>	<b>2,194,570,629.29</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	191,676.60	191,676.60
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>773,650,680.75</b>	<b>580,108,566.00</b>	<b>841,003,059.14</b>	<b>2,194,762,305.89</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	397,130,590.31	397,130,590.31
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,306,600,680.75</b>	<b>1,070,534,704.29</b>	<b>1,238,549,547.49</b>	<b>3,615,684,932.53</b>
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,306,600,680.75</b>	<b>1,070,534,704.29</b>	<b>1,238,549,547.49</b>	<b>3,615,684,932.53</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	6,924,505.33	6,924,505.33
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,306,600,680.75</b>	<b>1,070,534,704.29</b>	<b>1,245,474,052.82</b>	<b>3,622,609,437.86</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-6,924,505.33	00.00	-6,924,505.33
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	376,368,483.45	376,368,483.45
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,306,600,680.75</b>	<b>1,063,610,198.96</b>	<b>1,621,842,536.27</b>	<b>3,992,053,415.98</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,885,389,400.00</b>	<b>1,883,992,823.49</b>	<b>1,396,576.51</b>	<b>99.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,885,389,400.00	1,883,992,823.49	1,396,576.51	99.9
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,882,378,900.00	1,880,982,823.49	1,396,076.51	99.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,580,410,700.00	1,579,189,209.00	1,221,491.00	99.9
210101	Үндсэн цалин	915,995,000.00	915,454,163.00	540,837.00	99.9
210102	Нэмэгдэл	664,415,700.00	663,735,046.00	680,654.00	99.9
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,377,100.00	33,244,622.81	132,477.19	99.6
210201	Тэтгэврийн даатгал	94,300.00	94,300.00	00.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,100.00	11,100.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,900.00	8,900.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,200.00	2,200.00	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	33,260,600.00	33,128,122.81	132,477.19	99.6
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	97,499,900.00	97,499,855.58	44.42	100.0
210301	Гэрэл, цахилгаан	17,326,900.00	17,326,919.58	-19.58	100.0
210302	Түлш, халаалт	74,066,600.00	74,066,602.00	-02.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,106,400.00	6,106,334.00	66.00	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	95,578,400.00	95,556,264.30	22,135.70	100.0
210401	Бичиг хэрэг	8,675,900.00	8,675,696.00	204.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	72,185,300.00	72,185,252.80	47.20	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,773,400.00	7,771,518.50	1,881.50	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	647,500.00	647,500.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,296,300.00	6,276,297.00	20,003.00	99.7
2105	<b>Нормативт зардал</b>	21,700,000.00	21,699,779.00	221.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	499,987.00	13.00	100.0
210502	Хоол, хүнс	20,616,100.00	20,616,092.00	08.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	583,900.00	583,700.00	200.00	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,060,000.00	35,042,444.80	17,555.20	99.9
210604	Урсгал засвар	35,060,000.00	35,042,444.80	17,555.20	99.9
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	14,360,000.00	14,360,000.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	14,360,000.00	14,360,000.00	00.00	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	2,392,800.00	2,392,737.00	63.00	100.0

	<b>хураамж</b>				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.00	800,000.00	00.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	195,000.00	195,000.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	965,800.00	965,737.00	63.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,000,000.00	1,997,911.00	2,089.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,997,911.00	2,089.00	99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,010,500.00	3,010,000.00	500.00	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,010,500.00	3,010,000.00	500.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,010,500.00	3,010,000.00	500.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,885,389,400.00</b>	<b>1,883,992,823.49</b>	<b>1,396,576.51</b>	<b>99.9</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,830,163,400.00	1,823,657,479.49	6,505,920.51	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,830,163,400.00	1,823,657,479.49	6,505,920.51	99.6
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	55,226,000.00	60,335,344.00	-5,109,344.00	109.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,226,000.00	60,335,344.00	-5,109,344.00	109.3

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	<b>19,344,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	<b>19,344,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	19,344,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	5,534,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	5,534,050.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	0.00	3,150,000.00
210502	Хоол, хүнс	0.00	315,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	2,835,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	8,319,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	420,000.00
210602	Тавилга	0.00	7,779,950.00
210604	Урсгал засвар	0.00	120,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	2,340,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,340,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	19,344,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	19,344,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	120,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	16,884,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,340,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		